



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 02

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн аудитын дүгнэлтийг сонсч, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцлээ.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Тус компаний 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн аудитын зөвлөмжид тайлант оны 12 дугаар сарын үйл ажиллагааны орлого 612.5 сая төгрөгийг хүлээн зөвшөөрч тайлагнаагүй, бараа үйлчилгээг худалдан авахдаа 91.5 сая төгрөгийн бараа материалыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөөгүй, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зэрэг зөрчлүүдэд хязгаарлалттай дүгнэлт гаргасан тул холбогдох ажилтнуудад хариуцлага тооцохыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д үүрэг болгов.

2. Цаашид “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу санхүүгийн тайланг үнэн зөв, зөрчилгүй тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/, СБХ-ийн дарга /Д.Гэрэлчулуун/-д даалгав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



Д.БАТЗОРИГ



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 03

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН нь: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны ажлын тайлангийн тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны тогтоол шийдвэрийн биелэлт, ажлын тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Нарантуяа/-д даалгав” гэжээ.

ДАРГА  Д.БАТЗОРИГ



**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 06

Хэрлэн сум

**“Компанийн 2020 оны аудитлагдсан жилийн 7
эцсийн санхүүгийн тайлангийн дүнгийн тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 96.5, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.12 дахь заалт, Үндэсний аудитын газрын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 07/911 тоот дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн а/648 тоот удирдамжийг түс түс үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2020 оны нийт нийт хөрөнгийг 98,877,171,515 /ерэн найман тэрбум найман зуун далан долоон сая нэг зуун далан нэгэн мянга таван зуун арван тав/ төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 95,552,940,788.56 /ерэн таван тэрбум таван зуун тавин хоёр сая есөн зуун дөчин мянга долоон зуун наян найман төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 3,324,230,726.46 /гурван тэрбум гурван зуун хорин дөрвөн сая хоёр зуун гучин мянга долоон зуун хорин зургаан төгрөг дөчин зургаан мөнгө/ төгрөгөөр, эзэмшигчийн өмчийг 82,475,155,409.46 /наян хоёр тэрбум дөрвөн зуун далан таван сая нэг зуун тавин таван мянга дөрвөн зуун есөн төгрөг дөчин зургаан мөнгө/ төгрөгөөр, нийт авлагыг 1,113,170.625.24 /нэг тэрбум нэг зуун арван гурван сая нэг зуун далан мянга зургаан зуун хорин таван төгрөг хорин дөрвөн мөнгө/ төгрөгөөр, нийт өр төлбөрийг 16,347,613,839.66 /арван зургаан тэрбум гурван зуун дөчин долоон сая зургаан зуун арван гурван мянга найман зуун гучин есөн төгрөг жаран зургаан мөнгө/ төгрөгөөр санхүүгийн тайлан тэнцлийн дүнг баталсугай.

2. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, баталгаажуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Д.Батзориг/, Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д тус тус даалгасугай.

3. 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг улирал тутам Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.



Д.БАТЗОРИГ



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 07

Хэрлэн сум

Компанийн 2020 оны зорилтот түвшингийн
биелэлт, Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын
гэрээний үүргийн биелэлтийн тухай


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 83.6, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.12 дахь заалт, Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактыг дүгнэх, урамшуулал олгох түр журам”, Эрчим хүчний сайдын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн а/648 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компани 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатартай байгуулсан 2020 оны “Контрактын гэрээ”-ний үүргийн биелэлтийг 82.4 оноотойгоор “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Компанийн 2020 оны зорилтот түвшин болон Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын гэрээний үүргийн биелэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, баталгаажуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Д.Батзориг/, Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д тус тус даалгасугай.



Д.БАТЗОРИГ



"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2020 ОНЫ ЗОРИЛТОТ ТҮВШИН, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

д/д	Үзүүлэлтүүд	хэмжих нэгж	2020 он		Төлөвлөгөөтэй		Оноо	
			телев	гүйцэтгэл	зөрүү	хувь	Авбал зохих	Авсан
1	Эдийн засгийн үзүүлэлт							
1	Боловсруулсан ЦЭХ	сая. кВтц	217.1	234.0	16.9	107.8	5	5
2	Нийт түгээх ЦЭХ	сая. кВтц	229.6	256.0	26.3	111.5		
	Өөрийн түгээх ЦЭХ	сая. кВтц	185.7	201.4	15.8	108.5		
	ХАЦЭХ	сая. кВтц	43.7	54.3	10.6	124.2		
	Импортын ЦЭХ	сая. кВтц	0.258	0.260	0.0	101.0		
3	Түгээлт ДЭХ	мян. Гкал	294.2	312.1	17.9	106.1	5	5
4	Дотоод хэрэглээний цахилгаан эрчим хүч	хувь	14.5%	13.9%	-0.5%	96.3		
5	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал	хувь	7.6%	7.3%	-0.3%	96.1%		
6	Нийт орлого	сая.төг	42,897.0	47,292.6	4,395.6	110.2	5	5
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая.төг	42,237.5	46,244.0	4,006.5	109.5		
7	Нийт зардал	сая.төг	45,543.8	46,970.3	1,426.4	103.1	5	5
	Үүнээс : Удирдлагын зардал	сая.төг	337	319	(18.0)	94.7		
8	Татвар төлөхийн өмнөх ашиг	сая.төг	(2,646.8)	322.3	2,969.2	-12.2	10	10
	ААНОАТатвар	сая.төг	-	19.9	19.9	0.0		
	Цэвэр ашиг /алдагдал /	сая.төг	(2,646.8)	302.4	2,949.3	-11.4		
9	Төрийн өмчийн ногдол ашиг	сая.төг	-	-	-	0.0	5	5
10	БО-ын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.062	0.993	(0.1)	93.5	5	5
11	Нийт авлага	сая.төг	225.5	1,113.3	887.8	493.7	5	3.1
12	Нийт өглөг	сая.төг	12,155.4	11,839.7	(315.7)	97.4		
	Үүнээс : Богино хугацаат өглөг	сая.төг	4,000.0	3,705.9	(294.1)	92.6		
13	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	6,254.3	6,265.8	11.5	100.2	5	4.6
14	Түлшний хувийн зарцуулалт ЦЭХ	гр/кВтц	636.1	632.9	(3.2)	100.5	5	5
	ДЭХ	кг/Гкал	192.3	192.0	(0.3)	100.1		
2	Тайлангийн үр дүн							
2.1	Тухайн жилийн тайлан тэнцлийн аудитын дүгнэлт, сүүлийн 2 жилийн зөвлөмжийн хэрэгжилт						6	4.4
2.2	Захирлын ажлын тайлан						2	2
2.3	Шийдвэрийн хэрэгжилт / ЭХЯ, ТӨБЗГ/						5	4.6
2.4	Худалдан авах ажиллагааны тухай хууль, шилэн дасны хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн биелэлт						5	3.6
3	Үйлдвэрлэлийн осол аваарь, 1.2 дугаар зэргийн саатал						15	10.1
	ТУЗ-ӨӨС ӨГСӨН ДҮН						93	82.4
4	Хэрэглэгчийн санал асуулгын дүн						3	
5	Ажиллагсдын санал асуулгын дүн						4	
	НИЙТ ДҮН						100	



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 08

Хэрлэн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн а/12 тоот тушаал, Эрчим хүчний сайдын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн а/648 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг 102,897,600 /Нэг зуун хоёр сая найман зуун ерэн долоон мянга зургаан зуу/ төгрөг буюу хавсралт ёсоор дэмжсүгэй.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Нарантуяа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.БАТЗОРИГ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

/төгрөг/

Зардлын үзүүлэлт	2021 төлөвлөгөө			
	Хүн	Тарифт	Сард	Жилд
1. Цалингийн зардал	10		5,520,000.0	83,400,000.0
ТУЗ-ын дарга	1	750,000	750,000.0	9,000,000.0
Гишүүд	8	700,000	5,600,000.0	67,200,000.0
Нарийн бичгийн дарга	1	600,000	600,000.0	7,200,000.0
2. НДШимтгэл			1753485	12,093,000.0
3. Томилолтын зардал			-	6,564,600.0
Унаа	9	214,700	1,932,300.0	3,864,600.0
Байр, хоол /хүн-хоног/	9	50,000	1,350,000.0	2,700,000.0
4. Бичиг хэрэг			12,000.0	180,000.0
Бичиг хэрэг			15,000.00	180,000.00
5. Хурлын зардал			55,000.00	660,000.00
ДҮН			8,574,800.0	102,897,600.0



**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 09

Хэрлэн сум

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.8, 76.1.12, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 4.1, 7.3.13 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн а/648 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн 2020 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлийн дүнгээр тайлант үед 302,445,922.67 /гурван зуун хоёр сая дөрвөн зуун дөчин таван мянга есөн зуун хорин хоёр төгрөг жаран долоон мөнгө/ төгрөгийн ашигтай ажилласан тул балансын цэвэр ашгийн 15 хувиар тооцож компанийн хувьцаа эзэмшигчдэд 45,366,888.4 /дөчин таван сая гурван зуун жаран зургаан сая найман зуун наян найман мянган төгрөг дөрөв мөнгө/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг дэмжсүгэй.

2. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо /Ш.Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.



Д.БАТЗОРИГ



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 02-нд

Дугаар 10

Хэрлэн сум

“Нэр дэвшүүлэх түр хороо байгуулах тухай”

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн а/648 албан тоотыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх түр хороог дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Дарга: Б.Баясгаланбаатар

Гишүүд: В.Дарханбаатар

С.Ариунболд

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалт үйл ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн ажиллахыг Нэр дэвшүүлэх түр хороо /Б.Баясгаланбаатар/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Д.БАТЗОРИГ